

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Оршил

Монгол Улсын тариалангийн салбар нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн эрсдэлд хамгийн эмзэг салбаруудын нэг хэвээр байна. Ган, хуурайшилт, хэт халалт, хур тунадасны дутагдал, хөрсний чийгийн хомсдол зэрэг цаг уурын эрсдэл нь ургацын алдагдлыг нэмэгдүүлж, тариаланчдын орлогыг тогтворгүй болгож, улмаар хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлт, орон нутгийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлж байна. Өнөөгийн нөхцөлд байгалийн гамшиг, цаг уурын тааламжгүй үзэгдлийн дараа төсвөөс нөхөн олговор олгох арга хэмжээ нь урьдчилан тооцоход хүндрэлтэй, төсвийн сахилга батад дарамт учруулдаг, мөн эрсдэлд өртсөн бүх тариаланчийг тэгш, шуурхай хамарч чаддаггүй сул талтай байна.

Иймд тариалангийн салбарын эрсдэлийг урьдчилан удирдах, тариаланчдын орлогын тогтвортой байдлыг хангах, төрийн төсөвт ирэх гэнэтийн дарамтыг бууруулах, даатгалын зах зээлийг тогтвортой хөгжүүлэх зорилгоор индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх бие даасан, цогц эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Энэхүү хуулийн төсөл нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, индексэд суурилсан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах, индексийн мэдээллийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах, эрсдэлийг олон давхар түвшинд хуваарилах, нөхөн төлбөр олгох, даатгуулагчийн эрхийг хамгаалах, төрийн дэмжлэг болон давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг иж бүрнээр зохицуулахад чиглэж байна.

1. Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт

Энэхүү хуулийн төсөл нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, гэрээний нөхцөлийг тодорхой болгох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч болон даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэж байна.

Хуулийн төсөлд индексжүүлсэн даатгалын үндсэн онцлог болох бодит хохирлыг газар дээр нь заавал үнэлэхгүй, харин албан ёсны, тогтмол, шалгагдахуйц, даатгалын нэгжид төлөөлөх чадвартай индексийн үзүүлэлтэд үндэслэн нөхөн төлбөр олгох зарчмыг хуульчилсан. Индексийн төрөлд хур тунадас, ган, температур, халуун, хөрсний чийг, таримлын өсөлт, саатлыг зайнаас тандан судлах үзүүлэлт, сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индекс, түүнчлэн хоёр ба түүнээс дээш индексийн хосолсон бүтээгдэхүүн хамаарна.

Хуулийн төсөл нь индексийн үзүүлэлт болон даатгуулагчид бодитоор учирсан хохирол хооронд бүрэн нийцэл үүсэхгүй байх эрсдэл буюу суурь зөрүү үүсэх боломжийг хүлээн зөвшөөрч, түүнийг бууруулах, даатгуулагчид урьдчилан ойлгомжтой тайлбарлах, олон индекс ашиглах, даатгалын нэгжийг нарийсгах, нөхөн төлбөрийг шаталсан болон хэсэгчлэн байдлаар олгох механизмыг ашиглах боломжийг тусгасан.

Төслийн хүрээнд тариалангийн индексжүүлсэн даатгал нь дараах үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд: сайн дурын, тэгш хүртээмжтэй байх; индекс тооцох, нөхөн төлбөр олгох аргачлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод байх; эрсдэлийг хуваарилах давхар хамгаалалттай байх; суурь зөрүүний талаар даатгуулагчид урьдчилан мэдээлэх; өгөгдлийн чанар, баталгаажуулалт, хараат бус хяналтыг хангах; даатгуулагч, даатгагчийн эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, маргаан шийдвэрлэх тодорхой журамтай байх.

Хуулийн төслийн нэг чухал зохицуулалт нь даатгалын хамрах нэгжийг илүү тодорхой болгож, таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, газар зүйн мэдээллийн системд суурилсан талбар, даатгалын хугацаатай уялдуулан тогтоож байгаа явдал юм. Даатгуулагч нь даатгалд хамруулах талбайн эзэмших, ашиглах эрхийн баримт бичиг, эсхүл хууль ёсны ашиглалтын нотолгоог бүрдүүлэх бөгөөд даатгалд хамрагдах талбайг газар зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, индексийн тооцоонд ашиглахаар тусгасан.

Мөн хуулийн төсөлд индексийн мэдээллийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах тогтолцоог тусгайлан тодорхойлж, индексийн мэдээлэл цуглуулах, хэмжих, түүнд үндэслэн тооцоолол хийж тайлагнах, итгэмжлэгдсэн хараат бус хянан баталгаажуулагчийн дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр даатгуулагч болон олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааны цогцыг “Хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж тодорхойлсон. Энэ тогтолцоо нь индексийн мэдээллийн ил тод байдал, найдвартай байдал, хяналтын чанарыг сайжруулахад чиглэнэ.

Хуулийн төсөл нь нөхөн төлбөрийн тогтолцоог илүү боловсронгуй болгож, индексийн үзүүлэлт даатгалын тохиолдлын босгыг хангаж, түүнээс давсан хэмжээнээс хамааран нөхөн төлбөрийн хэмжээ шаталсан байдлаар нэмэгдэх; эрсдэлийн дунд түвшний босго хэмжээнд хүрсэн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгох; дунд түвшний босгоос цааш өссөн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн болон шаталсан байдлаар олгох зохицуулалтыг тусгасан. Нөхөн төлбөрийн хүснэгт нь даатгалын гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд индексийн босго, өөрчлөлтийн түвшин бүрд харгалзах нөхөн төлбөрийн хувь, төлбөрийн дээд хязгаар, хэсэгчлэн болон шаталсан байдлаар олгох нөхцөлийг агуулна.

Түүнчлэн даатгалын гэрээнд Иргэний хууль, Даатгалын тухай хуульд зааснаас гадна таримлын төрөл, талбай, хугацаа, даатгалын хамрах нэгж, индексийн төрөл, мэдээллийн эх үүсвэр, тооцооллын тайлбар, босго үзүүлэлт, нөхөн төлбөр тооцох хүснэгт, даатгалын дүн, өөрийн хариуцах эрсдэлийн хэмжээ, зах зээлийн нэгжийн дундаж үнэд суурилсан нөхөн төлбөрийн хувь, нөхөн төлбөр олгох хугацаа, суурь зөрүүний тайлбар, мэдрэгч төхөөрөмж байршуулах нөхцөл,

таван жил дараалан даатгуулсан боловч нөхөн төлбөр аваагүй даатгуулагчид үзүүлэх хураамжийн хөнгөлөлтийн нөхцөлийг тусгахаар тусгайлан зохицуулсан.

Даатгуулагчийн эрхийг хамгаалах хүрээнд даатгагч нь индексийн утга, тооцооллын аргачлал, болзошгүй суурь зөрүүний эрсдэл, нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөлийн талаар урьдчилан энгийн, ойлгомжтой хэлбэрээр мэдээлэх, мөн даатгалын бүтээгдэхүүний үндсэн нөхцөл, эрсдэл, нөхөн төлбөрийн зарчмыг товч, ойлгомжтой байдлаар харуулсан даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг заавал хүргүүлэхээр тусгасан. Даатгуулагчид шаардлагатай санхүүгийн боловсрол олгох сургалтыг холбогдох төрийн байгууллага, даатгагч хамтран зохион байгуулах зохицуулалт мөн тусгагдсан.

Эрсдэлийн хуваарилалтын хувьд хуулийн төсөлд доод түвшний эрсдэлийг даатгуулагч өөрөө, дунд түвшний эрсдэлийг даатгагчийн эрсдэлийн дунд түвшний сан, дээд түвшний эрсдэлийг эрсдэлийн дээд түвшний сан болон давхар даатгалаар хариуцах тогтолцоог хуульчилсан. Хамтын эрсдэлийн сан нь дунд түвшний эрсдэлийн сан, дээд түвшний эрсдэлийн сан, алдагдлаас хамгаалах сангийн нийлбэр зохион байгуулалт байх бөгөөд давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байхаар төсөлд тусгасан.

Түүнчлэн төрөөс тариалангийн индексжүүлсэн даатгалын хураамжийн тодорхой хувийг татаас хэлбэрээр санхүүжүүлж болох, татаасны хувь, хамрах хүрээ, зорилтот бүлгийг Засгийн газар батлах, индексжүүлсэн даатгалд хамрагдсан тариаланчдыг төрөөс олгох дэмжлэг, урамшуулалд нэн тэргүүнд хамруулах зохицуулалт тусгагдсан. Индекс тооцоход ашиглагдах цаг уурын ажиглалтын сүлжээ, зайнаас тандан судлалын мэдээлэл, ургацын статистикийн чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг төрөөс дэмжихээр мөн тусгасан.

Хуулийн хэрэгжилтийг бүх нийтийг хамруулсан байдлаар шууд эхлүүлэхгүй, харин туршилтын аймаг, суманд, эрсдэлийн үнэлгээ, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөр эхлүүлж, улмаар үе шаттай өргөжүүлэх шилжилтийн зохицуулалтыг төсөлд тусгасан нь бодит хэрэгжилтийн боломжийг хангах ач холбогдолтой.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Одоогийн эрх зүйн орчинд тариалангийн даатгалтай холбоотой харилцааг Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг ерөнхий хуулиудаар зохицуулж ирсэн боловч индексжүүлсэн даатгалын онцлог, тухайлбал индексийн төрөл, босго үзүүлэлт, суурь зөрүү, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, нөхөн төлбөрийн шаталсан болон хэсэгчлэн олгох загвар, индексийн мэдээллийг нийтэд мэдээлэх, даатгалын нэгжийг газар зүйн мэдээллийн системтэй уялдуулах, хэрэглэгчийн мэдээллийн тусгай хамгаалалт, эрсдэлийн олон давхар сан, давхар даатгалын тусгай зохицуулалт зэрэг асуудлыг иж бүрнээр тусгаагүй байна.

Иргэний хууль нь даатгалын гэрээний нийтлэг харилцааг зохицуулж, гэрээ байгуулах, талуудын эрх, үүрэг, даатгалын тохиолдол, нөхөн төлбөр олгох үндсэн зарчмыг тодорхойлсон. Гэвч бодит хохиролд бус индексийн үзүүлэлтэд тулгуурлан нөхөн төлбөр олгох, даатгалын нэгжид тооцогдох статистик болон агро-мэдээллийн үзүүлэлтийг ашиглах, нөхөн төлбөрийн хүснэгтийг индексийн өөрчлөлттэй уялдуулах, суурь зөрүүгийн эрсдэлийг урьдчилан тайлбарлах зэрэг индексжүүлсэн даатгалын онцлог харилцааг зохицуулаагүй байна.

Даатгалын тухай хууль нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх, даатгагч, давхар даатгагчийн эрх, үүрэг, санхүүгийн зохицуулалт, хяналтын нийтлэг асуудлыг зохицуулдаг. Уг хуульд даатгалын бүтээгдэхүүн боловсруулах, хураамж тогтоох, сан бүрдүүлэх зэрэг ерөнхий зохицуулалт байгаа боловч тариалангийн салбарын улирлын онцлог, уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлт, индексэд суурилсан нөхөн төлбөрийн механизм, эрсдэлийн олон түвшний хуваарилалт, суурь зөрүүг бууруулах арга, даатгалын нэгжийн кодчилол, индексийн мэдээллийг баталгаажуулах механизмын талаар тусгайлан зохицуулаагүй байна.

Тариалангийн тухай хууль нь тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, таримлын төрөл, бүсчлэл, тариалангийн бодлого, төрийн дэмжлэгийн ерөнхий чиглэлийг тогтоодог боловч уур амьсгалын эрсдэлийг даатгалын замаар удирдах, тэр дундаа индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн, индексийн мэдээлэл, нөхөн төлбөрийн тогтолцооны талаар тусгайлан зохицуулаагүй байна.

Үрийн тариалангийн даатгалын тухай хууль нь үрийн зориулалттай тариаланг тодорхой нөхцөлөөр даатгуулах тогтолцоог бүрдүүлж, байгалийн гамшиг, өвчин, хортон, түймрийн эрсдэлээс хамгаалах уламжлалт даатгалын зохицуулалтыг тогтоосон. Уг хуульд даатгалын хураамж, нөхөн төлбөр, гэрээ байгуулах хугацаа, хохирол тооцох аргачлал, төрөөс нөхөн төлбөрийн зөрүүг тодорхой хэмжээнд хариуцах, давхар даатгалд хамруулах боломжийг тусгасан хэдий ч индексжүүлсэн даатгалын үндсэн логик, индексийн эх сурвалж, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, суурь зөрүү, даатгалын бүтээгдэхүүний ил тод байдал, хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын тогтолцоог зохицуулаагүй байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль нь Монгол Улсад индексжүүлсэн даатгалын тодорхой туршлагыг бий болгосон бөгөөд эрсдэлийн сан, давхар даатгалын зохицуулалт, төрийн оролцооны хувьд тодорхой суурь өгч ирсэн. Гэвч мал аж ахуйн салбарын онцлогт тулгуурласан учраас тариалангийн салбарын үйлдвэрлэлийн мөчлөг, таримлын төрөл, тариалангийн талбайн байршил, ургацын хэлбэлзэл, агро-мэдээллийн бүтэц, индексийн төрөл, газар зүйн нарийвчлал зэрэг онцлогийг бүрэн тусгах боломжгүй юм. Иймд малын индексжүүлсэн даатгалын туршлагыг тодорхой хэмжээнд ашиглах боломжтой боловч тариалангийн индексжүүлсэн даатгалын онцлогт нийцсэн бие даасан хууль зайлшгүй шаардлагатай байна.

Иймээс дээр дурдсан хуулиуд нь тариалангийн даатгалтай холбоотой зарим харилцааг ерөнхий түвшинд буюу хэсэгчилсэн байдлаар зохицуулж ирсэн боловч индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах, индексийн мэдээллийг цуглуулах, баталгаажуулах, босго тогтоох, нөхөн төлбөрийг шаталсан байдлаар тооцох, хэрэглэгчийн мэдээллийн эрхийг хамгаалах, эрсдэлийн олон давхар

хамгаалалт бий болгох, төр–хувийн хэвшил–давхар даатгалын хамтарсан тогтолцоог цогцоор нь зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ нь тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай бие даасан хууль батлах бодит хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хуулийн төслийг боловсруулах явцад хууль санаачлагч болон ажлын хэсэг нь тариалангийн салбарын уур амьсгалын эрсдэлийн онцлог, таримлын бүсчлэл, индексийн өгөгдлийн бэлэн байдал, цаг уурын болон агро-мэдээллийн эх үүсвэр, ургацын статистик, зайнаас тандан судлалын мэдээлэл, газар зүйн мэдээллийн систем ашиглах боломж, даатгалын зах зээлийн бэлэн байдал зэрэг асуудалд дүн шинжилгээ хийсэн.

Мөн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, сургамж, тулгарсан хүндрэлүүдийг харгалзан үзэж, тариалангийн салбарт тохирсон зохицуулалт боловсруулах чиглэлээр ажилласан. Үүний хүрээнд индексийн төрөл, даатгалын нэгжийн тодорхойлолт, суурь зөрүүг бууруулах зохицуулалт, нөхөн төлбөрийн хүснэгт, эрсдэлийн сангууд, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, хэрэглэгчийн эрхийн хамгаалалтын шинэ зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн байгууллага, статистик, цаг уур, газар тариалан, санхүүгийн зохицуулалтын байгууллага, даатгалын компаниуд, мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, шинжээчдийн оролцоотой уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөлдөх ажиллагааг зохион байгуулж, тэдгээрээс ирүүлсэн саналыг төсөлд тусгасан. Даатгалын нэгжийн бүртгэл, индексийн мэдээллийн эх үүсвэр, мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл ашиглах боломж, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга, санхүүгийн боловсролын сургалт, туршилтын хэрэгжилт, татаасыг үе шаттай бууруулах асуудлыг төсөлд тусгасан нь энэ зөвлөлдөх ажиллагааны үр дүн болно.

Түүнчлэн хуулийн төсөл нь бодит хэрэгжилтийг хангах зорилгоор туршилтын аймаг, суманд эхлэн хэрэгжүүлэх, өгөгдлийн бэлэн байдал, эрсдэлийн үнэлгээ хангагдсан таримал, индексийн төрлөөр үе шаттай өргөжүүлэх, хэрэгжилтийн үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлэх шилжилтийн зохицуулалттай байхаар боловсруулагдсан.

4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн

Хуулийн төслийг боловсруулах явцад тариаланчид, даатгалын салбарын оролцогчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн төлөөллийн оролцоотой хэлэлцүүлэг, санал солилцох ажиллагааг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн явцад индексжүүлсэн даатгалын давуу болон сул тал, суурь зөрүүний эрсдэл, нөхөн төлбөр олгох босго, индексийн мэдээллийн ил тод байдал, даатгалын нэгжийн зохистой хэмжээ, даатгалын бүтээгдэхүүний ойлгомжтой байдал, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх хэлбэр, төрийн татаас, эрсдэлийн сангийн тогтолцоо, туршилтын хэрэгжилтийн ач холбогдлын талаар санал солилцсон.

Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан гол дүгнэлт нь индексжүүлсэн даатгал нь тариаланчдын хувьд эрсдэлийг бууруулах чухал хэрэгсэл болох боломжтой боловч индексжүүлж болох тариалангийн эрсдэлийн төрөл, даатгалын гэрээ, холбогдох журам, нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл, суурь зөрүүний утга агуулга, олон жил даатгуулж ирсэн даатгуулагчид үзүүлж болох урамшуулал, төрийн дэмжлэг зэрэг асуудлыг хуулийн төсөлд илүү тодорхой тусгах шаардлагатай гэсэн байр суурьтай байсан. Мөн даатгуулагчийн эрхийг хамгаалах үүднээс бүтээгдэхүүний товч танилцуулга заавал өгөх, индексийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх, индексийн маргаанд хараат бус эксперт, аудит ашиглах, даатгалын нэгжийг хэт томсгож суурь зөрүү нэмэгдэхээс зайлсхийх, туршилтын журмаар хэрэгжүүлж үр дүнд үндэслэн өргөтгөх нь зүйтэй гэж үзсэн.

Эдгээр саналуудыг хуулийн төсөлд тусган, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, туршилтын үе шаттай хэрэгжилтийг хуульчлах, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог оруулах, нөхөн төлбөрийн хүснэгтийг гэрээний салшгүй хэсэг болгох, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг даатгуулагчид заавал хүргүүлэх зохицуулалтыг илүү тодорхой болгосон.

5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт

Олон улсын туршлагаас үзэхэд АНУ, Энэтхэг, Мексик, Этиоп, Кени зэрэг улс орнууд тариалангийн индексжүүлсэн даатгалыг уур амьсгалын эрсдэлийг удирдах бодлогын чухал хэрэгсэл болгон ашиглаж байна. Эдгээр улсын туршлагаас индексийн өгөгдлийн чанар, төр–хувийн хэвшлийн хамтын оролцоо, давхар даатгалын хамгаалалт, хэрэглэгчид мэдээлэл өгөх тогтолцоо, санхүүгийн боловсрол, төрийн шилжилтийн татаас, бүтээгдэхүүнийг үе шаттай нэвтрүүлэх механизм нь амжилтын гол нөхцөл болдгийг харуулж байна.

Судалгаа, шинжилгээний тайлангуудаас харахад индексжүүлсэн даатгал нь гамшгийн дараах шууд төсвийн дэмжлэгээс илүү урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хуваарилах, зах зээлийн механизмд тулгуурласан тогтолцоо бөгөөд төсвийн сахилга батад эерэг нөлөөтэй болохыг харуулдаг. Гэхдээ индексийн төлөөлөх чадвар хангалтгүй, өгөгдлийн чанар сул, суурь зөрүү өндөр, хэрэглэгчид бүтээгдэхүүний нөхцөлийг ойлгоогүй тохиолдолд тогтолцооны үр ашиг буурдаг нь мөн тогтоогдсон.

Иймд хуулийн төсөлд гадаад орны туршлага, судалгааны дүгнэлтэд тулгуурлан дараах асуудлыг тусгасан. Үүнд: индексийн эх үүсвэрийн чанар, нягтралд шаардлага тавих; цаг уурын албан ёсны мэдээлэл, зайнаас тандан судлал, ургацын статистик, мэдрэгч төхөөрөмжийн мэдээллийг хослуулах боломж нээх; хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог бий болгох; суурь зөрүүг бууруулах зорилгоор даатгалын нэгжийг оновчтой тогтоох, олон индекс ашиглах боломж бүрдүүлэх; нөхөн төлбөрийг шаталсан болон хэсэгчлэн олгох хүснэгттэй болгох; төрийн татаасыг шилжилтийн шинжтэй байхаар зохицуулах; туршилтын журмаар эхэлж, үе шаттай өргөжүүлэх зохицуулалтыг тус тус оруулсан.

6. Зохицуулахаар тусгасан харилцааны нэр томьёо, агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай тайлбар

Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёог нэг мөр ойлгох, индексжүүлсэн даатгалын харилцааг зөв хэрэглэх зорилгоор үндсэн ойлголтуудыг тусгайлан тодорхойлсон.

“Тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд тухайн нэгжид тооцогдох индексийн үзүүлэлт босго хэмжээнээс давсан тохиолдолд нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагааг ойлгоно. Энэ нь уламжлалт хохиролд суурилсан даатгалаас ялгаатай үндсэн онцлог юм.

“Индекс” гэж хур тунадас, температур, хөрсний чийг, гангийн индекс, тариалангийн бүс дэх ургацын сумын дундаж индекс зэрэг тариалангийн эрсдэлийг төлөөлөх статистик үзүүлэлтийг ойлгоно. Индекс нь нөхөн төлбөр олгох үндэслэл болох тул албан ёсны, тогтмол, шалгагдахуйц, тухайн нэгжид төлөөлөхүйц нягтрал, чанартай байх шаардлагатай.

“Даатгалын нэгж” гэж даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож гэрээнд заасан таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, талбар, даатгалын хугацаагаар тодорхойлогдох, даатгалын үнэлгээ тогтоох суурь нэгжийг хэлнэ. Даатгалын нэгжийг зөв тогтоох нь суурь зөрүүг бууруулахад чухал нөлөөтэй.

“Босго үзүүлэлт” гэж даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор тогтоосон, индексийн утгын өөрчлөлтөөс хамааран нөхөн төлбөрийг хувь тэнцүүлсэн эсхүл шаталсан байдлаар олгох түвшнийг ойлгоно. Босго үзүүлэлт нь нэгдүгээр босго буюу даатгуулагчийн өөрийн эрсдэл, хоёрдугаар босго буюу даатгагч буюу хамтын сангийн хариуцах эрсдэл, дээд түвшний босго буюу давхар даатгал болон төрийн хамгаалалтын түвшнээр тогтоогдоно.

“Суурь зөрүү” гэж индексийн үзүүлэлт болон даатгуулагчид бодитоор учирсан хохирол хооронд бүрэн нийцэл үүсэхгүй байх эрсдэлийг ойлгоно. Энэ нь индексжүүлсэн даатгалын салшгүй шинж бөгөөд хуулийн төсөлд суурь зөрүүний талаар урьдчилан тайлбарлах, түүнийг бууруулах арга хэмжээг гэрээнд тусгах үүргийг даатгагчид ногдуулсан.

“Хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж индексийн мэдээлэл, холбогдох өгөгдлийг цуглуулах, хэмжих, түүнд үндэслэн тооцоолол хийж тайлагнах, итгэмжлэгдсэн хараат бус хянан баталгаажуулагчийн дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр даатгуулагч болон олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааны цогцыг хэлнэ. Энэ тогтолцоо нь индексийн найдвартай, ил тод, баталгаажсан байдлыг хангах ач холбогдолтой.

“Давхар даатгалын компани”, “эрсдэлийн дунд түвшний сан”, “эрсдэлийн дээд түвшний сан”, “алдагдлаас хамгаалах сан”, “хамтын эрсдэлийн сан” зэрэг ойлголт нь эрсдэлийг олон давхар хамгаалалтаар хуваарилах, даатгалын тогтолцооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой зохицуулалтын агуулгыг илэрхийлнэ.

Нөхөн төлбөрийг индексийн өөрчлөлтийн түвшинтэй уялдуулан шаталсан, хэсэгчлэн олгох зохицуулалт нь суурь зөрүүгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бөгөөд нөхөн төлбөрийн хүснэгтийг гэрээний салшгүй хэсэг болгон хуульчилснаар хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, урьдчилан тодорхой нөхцөл бүрдүүлж байгаа юм.

Мөн хуулийн төсөлд даатгуулагчийн талбайдаа мэдрэгч төхөөрөмж байршуулах нөхцөл, индексийн мэдээллийн эх үүсвэрийг өргөжүүлэн ашиглах боломж, таван жил дараалан тогтмол даатгуулсан боловч нөхөн төлбөр аваагүй даатгуулагчид хураамжийн хөнгөлөлт үзүүлэх нөхцөл зэрэг шинэчилсэн зохицуулалтыг тусгасан нь бүтээгдэхүүний уян хатан байдал, хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Дүгнэлт

Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл нь тариалангийн салбарын уур амьсгалын эрсдэлийг урьдчилан удирдах, тариаланчдын орлогын тогтвортой байдлыг хангах, хүнсний аюулгүй байдлыг дэмжих, төрийн төсөвт учрах гэнэтийн дарамтыг бууруулах зорилготой цогц, шинжлэх ухааны үндэслэлтэй зохицуулалт юм.

Хуулийн төслийн сүүлчийн хувилбарт индексийн төрөл, даатгалын нэгжийн нарийвчилсан зохицуулалт, газар зүйн мэдээллийн системийн бүртгэл, мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл ашиглах боломж, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, босго үзүүлэлтийн олон түвшин, нөхөн төлбөрийн хүснэгтийн нарийвчилсан зохицуулалт, хэрэглэгчийн мэдээллийн эрхийн хамгаалалт, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга, санхүүгийн боловсролын сургалт, эрсдэлийн олон давхар сан, төрийн татаас, туршилтын болон үе шаттай хэрэгжилтийн зохицуулалтыг тусгаснаараа өмнөх хувилбараас илүү боловсронгуй болсон.

Хууль батлагдсанаар тариалангийн индексжүүлсэн даатгалын эрх зүйн орчин бүрдэж, даатгалын зах зээлийн шинэ бүтээгдэхүүн хөгжих, тариаланчдын эрсдэлийн удирдлага сайжрах, даатгалын тогтолцооны ил тод байдал, тогтвортой байдал нэмэгдэх, улмаар тариалангийн салбарын тогтвортой хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулах нөхцөл бүрдэх юм.

---oOo---